

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар: 03

Улаанбаатар хот

**Компанийн жилийн үйл ажиллагааны
тайланг дүгнэх тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11, 80 дугаар зүйлийн 80.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9, Сангийн сайдын 2017 оны 01 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 3.3.18-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайланг үндэслэн “Үндэсний давхар даатгал” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг багцын давхар даатгалын гэрээ (трити)-ний хувьд хэрэгжүүлж ажилласан, хувь оролцооны давхар даатгалын гэрээ (факультатив)-ний хувьд хэрэгжүүлж ажиллаагүй, даатгалын хураамжийн орлогын төлөвлөгөө 7,6 тэрбум төгрөг буюу 17.2 хувиар дутуу бүрдүүлсэн, цэвэр ашиг 1,3 тэрбум төгрөг буюу 70.32% биелэлттэй, даатгалын зардал 17,9 тэрбум төгрөг буюу 115% хэтрэлттэй, нийт зардал 4,8 тэрбум төгрөг буюу 21.39% хэмнэлттэй ажилласан байна гэж дүгнэсүгэй.

2. Цаашид төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд анхаарч, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Ч.Тавинжил)-д даалгасугай.

4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо (Ц.Дашдондог)-нд үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ТАВИНЖИЛ